

АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
/ Оны эхний 2 сард /

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 1.3 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 58.8 %-иар давсан нь урьд оныхоос 0.5 тэрбумаар дээгүүр байна.

Асгат, Наран, Сүхбаатар, Уулбаян, Эрдэнэцагаан, Түмэнцогт сумдын төсвийн орлогын төлөвлөгөө нь 6.2-140.9 хувиар давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага 0.7 тэрбум төгрөг болжээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас ААНБ, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 21.1 тэрбум төгрөгт хүрч, 2010 оны жилийн эцсээс 1.5 тэрбум төгрөгөөр буюу 7,6 %-иар өсчээ.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 11.9 тэрбум төгрөг болж, 2010 оны жилийн эцсээс 0.5 тэрбум төгрөгөөр буюу 4.4 хувиар өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Малын онд оролт: Оны эхний 1979.8 мянган мал онд орж байгаа бөгөөд эхний 2 сард оны эхний малын 0.75 хувь болох 14.9 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.2 хувьтай байна.

Нийт хорогдсон малын 55.0 % нь ямаа, 36.5 % нь хонь эзлэж байна.

Хорогдлыг сумаар авч үзвэл: Асгат, Баяндэлгэр, Дарьганга, Наран, Онгон, Эрдэнэцагаан сумдын оны эхний малын 3.2-0.5 хувь болох 13.5 мянган мал хороогдоод байгаа нь нийт хорогдлын 90 гаруй хувийг эзэлж байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5 тэрбум төгрөг болж, борлуулалт 21.7 тэрбум төгрөгт хүрсэн нь урьд оны мөн үеэс доогуур гүйцэтгэлтэй байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн болон борлуулалт буурсан нь Андын илч ХХК нь үйлдвэрлэлт эрхлээгүйтэй холбоотой байна.

Гол нэр төрлөөс талх, хиам, нүүрс, дулаан үйлдвэрлэлт нэмэгдсэн.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс оны эхний 2 сард 2.2 хувиар өссөнд эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ, холбоо, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ, боловсролын үйлчилгээ, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний салбараас бусад бүх бүлгийн барааны үнэ тариф 0.1-4.2 хувь болтлоо өссөн нь нөлөөлжээ

VI. ЭРҮҮЛ МЭНД: 212 эх амаржиж, 214 хүүхэд төрсөн нь урьд оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 96 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 8-аар олон байгаа бөгөөд бруцеллөз, салхицэцэг, трихоминиаз, заг зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 993 болж, оны эхний 2 сард 86-аар нэмэгдсэн байна. Ажилгүй иргэдийн 82.7 хувь нь 16-34 насны залуучууд, 33.9 хувь нь бүрэн дунд, 22.8 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. Эхний 2 сард 178 хүн шинээр бүртгүүлж, 76 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 41 хүн ажиллаж байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: Бүртгэгдсэн гэмт хэрэг 22 байгаа нь урьд оны мөн үеэс доогуур байна. Гэмт хэргийн улмаас 8 хүн нас барж, 10 хүн гэмтэж осолдсон нь урьд оны мөн үеэс өссөн байна. ААНБ, иргэдэд 3.8 сая төгрөгийн хохирол учирсны 3.8 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 17 хүн сэжиглэгдсэний 47.1 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 532 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 1.6 дахин олон байгаа бөгөөд баривчлуулсан хүний тоо урьд онуудын мөн үеэс дээгүүр байна.

Статистикийн хэлтсийн дарга  О.Цэрэндулам.

